



Засгийн газрын 2022 оны 52 дугаар  
тогтоолын хавсралт

**"ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ, СУРГАЛТЫН ТӨВ"  
АЖ АХУЙН ТООЦООТОЙ ТӨРИЙН ӨМЧИТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ дүрмийн зорилго нь "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" (цаашид "Бэлтгэл, сургалтын төв" гэх) аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын эрх хэмжээ, үйл ажиллагааны болон хөрөнгө, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх журам, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Бэлтгэл, сургалтын төв нь Биеийн тамир, спортын улсын хорооны харьяанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зохион байгуулалтын хэлбэртэй байх бөгөөд өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.

1.3.Бэлтгэл, сургалтын төв нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг мөрдөн ажиллана.

1.4.Бэлтгэл, сургалтын төвийн оноосон бүтэн нэр "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар, товчилсон нэр "ҮШББСТ" ТӨҮГ байна.

1.5.Бэлтгэл, сургалтын төвийн оршин байгаа байршил нь улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн, Монгол улсад бүртгэлтэй хаягаар тодорхойлогдоно.

1.6.Бэлтгэл, сургалтын төв нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкны харилцах данс, цахим хаягтай байна. Цахим шуудангийн хаяг буюу E-mail: [nationalteamcenter.mn@gmail.com](mailto:nationalteamcenter.mn@gmail.com)

1.7.Бэлтгэл, сургалтын төвийн захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд тэмдгийг түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

**Хоёр.Бэлтгэл, сургалтын төвийн чиг үүрэг,  
үйл ажиллагааны чиглэл**

2.1.Бэлтгэл, сургалтын төв нь биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлд спортын шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагааг цогц хэлбэрээр явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.



2.2.Бэлтгэл, сургалтын төв нь үндсэн чиг үүргийн хүрээнд дараахь чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.2.1.үндэсний шигшээ багийн тамирчдын биеийн ерөнхий болон тусгай хөгжлийг сайжруулах, тамирчдын бэлтгэл, цугларалт, сургалт-дасгалжуулалтын орчин, бэлтгэлийн заал танхим, дотуур байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.2.2.спортын шинжлэх ухааны шинэ нээлт, ололт, нотолгоонд тулгуурласан техник, арга зүйг тамирчдын ажиллах чадвар, биеийн ерөнхий хөгжлийн болон тусгай хөгжлийн сургалт-дасгалжуулалтад ашиглах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, спортын анагаах ухааны анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх;

2.2.3.тамирчдын шинжилгээ, судалгааг олон улсын стандартад нийцүүлэн хийж, бүс нутаг, дэлхийн жишгийн хэмжээнд хүргэн хөгжүүлэх, тамирчдын ажиллах чадвар, биеийн ерөнхий хөгжлийн болон тусгай хөгжлийн сорил, тест хийх шинэ техник, технологийн болон спортын хоол судлалын шинэ арга зүйг нэвтрүүлэх;

2.2.4.нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ, үндэсний болон олон улсын спортын тэмцээн, наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлж иргэдэд чиглэсэн биеийн тамир, спортын төлбөрт үйлчилгээ үзүүлэх;

2.2.5.техникийн спортын төрлийн болон галт зэвсэг, техник хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй ажиллагаа, хяналт, хөдөлмөр хамгааллыг мөрдөн ажиллах талаар сургалт зохион байгуулах;

2.2.6.аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ баг, спортын холбоодод үндэсний шигшээ багийн нөөц тамирчин бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

2.2.7.бусад.

2.3.Бэлтгэл сургалтын төв нь үндсэн чиг үүргийн хүрээнд хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааг төлбөртэй эрхэлж болно.

2.4.Бэлтгэл, сургалтын төв нь татан буулгах, өөрчлөн байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарснаас бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

2.5.Бэлтгэл, сургалтын төв нь хуульд заасан тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрлийг авч, улсын бүртгэлд бүртгүүлсний дараа эрхэлнэ.

2.6.Бэлтгэл, сургалтын төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас санал болгосноор төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.



### Гурав.Бэлтгэл, сургалтын төвийн эд хөрөнгийн эрх

3.1.Бэлтгэл, сургалтын төв нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Бэлтгэл, сургалтын төв нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тогтоосон норматив хэмжээнд нийцүүлж үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн чадавхаа нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх эрхтэй.

### Дөрөв.Бэлтгэл, сургалтын төвийн удирдлага

4.1.Бэлтгэл, сургалтын төвийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.

4.2.Захирлыг биөийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.

4.3.Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2, 3-т заасан шаардлагыг хангасан байна.

4.4.Захирал нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасныг үндэслэн гэрээ байгуулна.

4.5.Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.5.1.Монгол Улсын хууль тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, ажлын үр дүнг тооцох, тайлагнах;

4.5.2.үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах болон техник, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны байдлыг хангах, технологийн горим, хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахиулах;

4.5.3.санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтын үр ашиг, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.5.4.ажилтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн дотоод журам болон төвийн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг зохих журмын дагуу баталж мөрдүүлэх;

4.5.5.санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэх чиглэлээр удирдлагын манлайллыг хангаж, үйл ажиллагаанд дотоод хяналтыг бэхжүүлэн мэргэжил, ажлын туршлагаа дайчлан ажиллах;



4.5.6.ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн төрийн болон албаны нууцыг хамгаалах, ажиллах хугацаанд, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа ил болгох хүртэл хугацаанд задруулахгүй байх;

4.5.7.хууль тогтоомжид заасан бусад.

4.6.Энэ дүрмийн 4.4-т заасан гэрээгээр байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан захирлын хэрэгжүүлэх нэмэлт эрх, үүргийг хуульд нийцүүлэн тогтоож болно.

4.7.Бэлтгэл, сургалтын төвийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилтот түвшинд биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын санал болгосон биеийн тамир, спортын арга хэмжээг тусгаж батална.

4.8.Захирал нь албан үүргээ гүйцэтгэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

4.9.Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4-т заасан болон хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүргийг давхар эрхлэх, байгууллагын хөрөнгөөр бусад этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргахыг хориглоно.

4.10.Захирал нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу хөрөнгө орлогоо мэдүүлэх үүрэгтэй.

4.11.Захирал хууль тогтоомж, энэ дүрмийг зөрчсөн, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь түүнд хариуцлага тооцох үндэслэл болно.

4.12.Захирлыг эзгүйд орлох албан тушаалтныг үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журамд заасан байна.

#### Тав.Санхүүжилт, санхүү, хөрөнгийн бүртгэл, тайлан

5.1.Бэлтгэл, сургалтын төвийн орлого нь санхүүгийн дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1.ажил, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааны орлого;

5.1.2.олон улсын аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний дагуу олсон орлого;

5.1.3.банкн дахь дансны үлдэгдлийн болон хадгаламжийн хүү;

5.1.4.улсын төсвийн санхүүжилт (тодорхой хэмжээгээр байж болно);

5.1.5.гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, иргэний хандив, тусламж, хандивлагч орнуудын зээл, буцалтгүй тусламж;



5.1.6.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

5.2.Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан холбогдох журам, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

5.3.Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан бүрэлдэхүүнээр гаргах бөгөөд дараахь мэдээллийг тусгана:

5.3.1.баланс;

5.3.2.орлого, үр дүнгийн тайлан;

5.3.3.мөнгөн гүйлгээний тайлан;

5.3.4.хуримтлагдсан ашгийн тайлан;

5.3.5.өмчийн өөрчлөлтийн тайлан;

5.3.6.тухайн тайлангийн хугацаанд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал;

5.3.7.нэмэлт тайлбар, тодруулга;

5.3.8. бусад.

5.4.Бэлтгэл, сургалтын төв нь өөрийн эзэмшлийн эд хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэж, хадгалалт, хамгаалалтын ажлыг гүйцэтгэх бөгөөд эд хөрөнгийн дотоодын тооллогыг хуульд заасан хугацаанд явуулж, жилийн тайлан, тэнцэлд тусгана.

5.5.Бэлтгэл сургалтын төвийн санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

5.6.Бэлтгэл, сургалтын төв нь тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө, санхүү, үр дүнгийн тайланг, илтгэх бичгийн хамт Биенийн тамир, спортын улсын хороо болон төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

5.7.Энэ дүрмийн 5.3-т заасан тайланд дараахь мэдээллийг тусгана:

5.7.1.тайлангийн хугацаанд эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

5.7.2.Бэлтгэл, сургалтын төвийн албан тушаалтан, ажилтнуудад тайлангийн хугацаанд олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ;

5.7.3.шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.



5.8.Бэлтгэл, сургалтын төвийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн аудитын шалгалтыг Үндэсний аудитын газраас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу хийлгэнэ.

5.9.Бэлтгэл, сургалтын төвийн нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр захирал томилж, чөлөөлнө.

5.10.Бэлтгэл, сургалтын төвийн үйл ажиллагаанд зориулж шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

5.11.Бэлтгэл, сургалтын төв нь Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

#### Зургаа.Дотоод хяналт, шалгалт

6.1.Бэлтгэл, сургалтын төв нь хөрөнгийн хадгалалт, хамгаалалт болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллана.

6.2.Дотоод хяналтын ажиллах журмыг Засгийн газрын баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн захирал батална.

6.3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн үйл ажиллагаанд аудитын байгууллагын дүгнэлт гаргуулж ажиллана.

6.4.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих бүртгэлийн хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна.

#### Долоо.Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн хадгалалт

7.1.Бэлтгэл, сургалтын төв нь албан хэрэг хөтлөлт, хадгалалтын нийтлэг журмыг мөрдөх бөгөөд дараахь баримт бичгийг хадгална:

7.1.1.Бэлтгэл, сургалтын төвийн дүрэм, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, үүсгэн байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, сертификат;

7.1.2.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн аудитын болон хэрэгжилтийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж;

7.1.3.анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

7.1.4.Бэлтгэл, сургалтын төвийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой гэрээ хэлэлцээр;

7.1.5.улсын төсөв, гадаад, дотоодын байгууллагын санхүүжилтээр зохион байгуулсан худалдан авах ажиллагааны талаарх бичиг баримт;



7.1.6.тамирчдын судалгаа, шинжилгээ, сорил, тест, өвчний түүх, спортын анагаах ухааны хяналтын бичиг баримт;

7.1.7.захирал, эрх бүхий албан тушаалтны шийдвэр болон төвийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар, стандарт, холбогдох бусад баримт бичиг;

7.1.8.төвийн үйл ажиллагаа, үйлчилгээ, үр дүнгийн талаарх статистик мэдээлэл;

7.1.9.цахим бичиг баримт, мэдээлэл;

7.1.10.бусад ач холбогдол бүхий бичиг баримт.

7.2.Энэ дүрмийн 7.1-д заасан баримт бичгийг бүрдүүлэх, хүлээн авах, хадгалах ажиллагааг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

#### Найм.Бусад

8.1.Бэлтгэл, сургалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой энэ дүрэмд тусгагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

8.2.Бэлтгэл, сургалтын төвийг татан буулгах, өөрчлөн байгуулах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу Засгийн газар шийдвэрлэнэ.

8.3.Энэ дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.4.Засгийн газрын шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

---000---

